

**СЭЛЭНГЭ АЙМАГТ 2019 ОНЫ 6-Р САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019.06.04

| № | Хийгдэх ажил, арга хэмжээ | Хугацаа | Хэрэгжүүлэх хэлтэс, алба, газар | Хариуцах эзэн |
|--|---|------------------------|--|------------------------|
| Нэг.Удирдлага зохион байгуулалтын хүрээнд | | | | |
| 1 | “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн тайланг иргэд, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах | Сардаа | Аймгийн Засаг даргын Тамгын газар | Ө.Сувдаа |
| 2 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2019 оны хагас жилийн тайланг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх | 6-р сарын 31-ний дотор | Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс | Ө.Сувдаа Б.Болорзул |
| 3 | Төрийн албаны тухай хууль, түүнийг дагалдан гарсан дүрэм, журмуудын танилцуулга сургалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулах | 6-р сарын 14 | Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл | Ө.Сувдаа |
| 4 | Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Бүсчлэлийн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журам”-ын хэрэгжүүлэх, шуудангийн нэгдсэн кодыг хэрэглэх тухай танилцуулга сургалтыг зохион байгуулж, аймаг, сумын газрын харилцааны асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон аймгийн төвийн төр төсвийн байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтнуудыг хамруулах | 6-р сарын 21 | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс | Б.Болорзул |
| 5 | “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт”-ийн улсын үзлэгт бэлтгэх ажлыг зохион байгуулж, сумдад ажлын хэсгийг ажиллуулах | Сардаа | Хууль, эрх зүйн хэлтэс | Д.Ёндонжамц |
| 6 | Гэмт хэргийн илрүүлэлтийг сайжруулах, Шүүхийн шинжилгээний албаны АДИС-Папилон сангийн баяжилтийг ахиулах зорилгоор "Дардас" нэгдсэн арга | Сардаа | Шүүхийн шинжилгээний алба, Гэмт хэргээс | У.Төгөлдөр |

| | | | | |
|---------------------------------------|---|------------------------|--|----------------|
| | хэмжээг зохион байгуулах | | урьдчилан сэргийлэх аймгийн зөвлөл | |
| 7 | Сэлэнгэ аймгийн 2019 оны 05 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргах, тархах | 6-р сарын 15-ны дотор | Статистикийн хэлтэс | Д.Гүндэгмаа |
| 8 | Малын түүвэр хагас жилийн судалгааг зохион байгуулах | 6-р сарын 14-ний дотор | Статистикийн хэлтэс | Д.Гүндэгмаа |
| 9 | 2019 оны 2-р улирлын татварын тайланг хүлээн авахтай холбогдуулан татвар төлөгчдөд зөвлөмж хүргүүлэх | Сардаа | Татварын хэлтэс | Х.Батболд |
| Хоёр.Нийгмийн салбарын хүрээнд | | | | |
| 1 | 2018-2019 оны хичээлийн жилд суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын гэрчилгээ, үнэмлэх олгох ажлыг зохион байгуулах | Сардаа | Боловсрол, соёл, урлагийн газар | Ч.Жаргалсайхан |
| 2 | Элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулах | Сардаа | Боловсрол, соёл, урлагийн газар | Ч.Жаргалсайхан |
| 3 | Сайхан сумын сум дундын эмнэлэг, Дулаанхаан тосгоны Эрүүл мэндийн төв, “ЭБУС”, “ТАНА”, “Итгэлт ачтан” эмнэлгүүдүүдэд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Магадлан итгэмжлэл хийх ажлыг зохион байгуулах | Сардаа | Эрүүл мэндийн газар | Ж.Од |
| 4 | 2019 оны 1-р улиралд эндсэн амьгүй төрөлт, нярайн эндэгдлийн тохиолдлын магадлан хэлэлцэх хурлыг зохион байгуулах | Сардаа | Эрүүл мэндийн газар | Ж.Од |
| 5 | Тамхины эсрэг дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх | Сардаа | Эрүүл мэндийн газар | Ж.Од |
| 6 | Сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэгийг Мандал сумын Хэрх, Түнхэл тосгодод зохион байгуулах | Сардаа | Эрүүл мэндийн газар | Ж.Од |
| 7 | Сүхбаатар, Мандал сумын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй нийт 300 иргэн, хүүхдийг сэргээн засах үйлчилгээнд хамруулах | Сардаа | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Л.Зоригтбаатар |
| 8 | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төслийг хэрэгжүүлэх | Сардаа | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Л.Зоригтбаатар |

| | | | | |
|---|---|----------------|---|----------------|
| 9 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр арга хэмжээнд иргэдийг хамруулах | Сардаа | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | Л.Зоригтбаатар |
| 10 | Баар, зочид буудал, массаж, сауны газруудад “Насанд хүрээгүй хүнийг хориглосон ажлын байрны жагсаалт”-ын дагуу урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах | Сардаа | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | П.Оюун |
| 11 | Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэх ажлыг зохион байгуулах | Сардаа | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | П.Оюун |
| 12 | “Зөв тусгал” аяныг аймгийн хэмжээнд өрнүүлэх | Сардаа | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | П.Оюун |
| 13 | Мини волейболын өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах | Сардаа | Биеийн тамир, спортын газар | У.Батмөнх |
| 14 | “Хөтөл марафон” гүйлтийн тэмцээнийг зохион байгуулах | Сардаа | Биеийн тамир, спортын газар | У.Батмөнх |
| Гурав.Хөгжлийн бодлогын хүрээнд: | | | | |
| 1 | Оюуны өмчийн газартай хамтран жижиг дунд бизнес эрхлэгчдэд сургалт зохион байгуулах | 6-р сарын 4-нд | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, | А.Эрдэнэгэрэл |
| 2 | АДРА ОУ-ын байгуулагаас хэрэгжүүлж буй “Органик хөдөө аж ахуйн түншлэл” төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийг Монгол Улсын анхны “Хамтын баталгаажуулалтын байгуулага” болгох ёслолын арга хэмжээг зохион байгуулах | 6 сарын 13-нд | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, | А.Эрдэнэгэрэл |
| 3 | Аймаг, сумын төв, томоохон суурингийн 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зургийг агентлагийн холбогдох хэлтэстэй хамтран MNS 6702:2017 стандартад шилжүүлэх ажлыг зохион байгуулах | Сардаа | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар | Б.Саруултөгс |
| 4 | Бэлчээрийн газрыг фотомониторингийн аргаар үнэлэх ажлын 2018 оны үр дүнг ашиглан аймгийн бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал болон бэлчээрийн экологийн чадавхийн зураглалыг шинээр хийх | Сардаа | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар | Б.Саруултөгс |

| | | | | |
|---|--|--------|--|-------------------------|
| 5 | Хаврын тариалалтын эцсийн мэдээг нэгтгэж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэх | Сардаа | Хүнс хөдөө аж ахуйн газар | Б.Мөнхтөр |
| 6 | “Бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошго дээр органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ, мэдэгдлийг хуурамчаар үйлдэж, байршуулсан эсэхэд хяналт шалгалт” явуулж, үр дүнг мэдээлэх | Сардаа | Хүнс хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар | Б.Мөнхтөр Ж.Отгонхүү |
| 7 | Жижиг, дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах төслүүдийг хүлээн авч, бүртгэлийн программд шивж оруулах | Сардаа | Хүнс хөдөө аж ахуйн газар | Б.Мөнхтөр |
| 8 | Цөлжилтийн судалгаа хийхээр шалгарсан байгууллагуудтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, сумдыг судалгаанд хамруулах ажлыг зохион байгуулах | Сардаа | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | З.Түвшинтөгс |
| 9 | Сэлэнгэ голын сав газартай хамтран усны тооллого явуулах, Хараа, Ерөө голын сав газрын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах | Сардаа | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | З.Түвшинтөгс |

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР